

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН ОЛОЛТ АМЖИЛТ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ, ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ

СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ” АНХДУГААР
ЧУУЛГА УУЛЗАЛТ

Чойбалсан хот, Дорнод аймаг
2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр

Д.Саран-Эрдэнэ, Төв аймгийн ЗДТГ-ын
ХОХБТ-ийн хэлтсийн дарга

МАНЛАЙЛАЛ

- Тодорхой сэдэл зорилготой хүн нөөцөө ашиглан бусдын сэдлийг сэргээж, оролцуулж, хүсэл зоригийг нь хангахыг МАНЛАЙЛАЛ гэнэ.
- Манлайлал бол бусдын зан үйлд нөлөө үзүүлэхийг оролдох үйл явц
- Манлайлагч бол тодорхой эрх мэдлээр дамжуулан хүмүүст нөлөө үзүүлж, араасаа дагуулахыг оролддог хүн.

МАНЛАЙЛЛЫН 4 ҮҮРЭГ

- **Үлгэрлэх.** Үзэл баримтлал, эрхэм зорилгоо тууштай хамгаалж, бусдад үг хэл, үйл хөдлөлөөрөө үлгэрлэж байх
- **Чиглүүлэх.** Хүрэх газар, явах замыг зааж өгөх
- **Бусдыг зоригжуулах.** Хүмүүст юмыг үнэн сэтгэлээсээ хийж бүтээх боломж, нөхцлийг нь бүрдүүлж өгөх
- **Нэгтгэх.** Харилцан итгэлцлийн уур амьсгалыг бий болгож, хамт олноо нэгэн зүгт хөдөлгөх

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Дэлхийн аль ч оронд, ямар ч салбарт, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дээд удирдлагад эмэгтэйчүүд эрчүүдээс цөөхөн байдаг.

Үүнийг нотолсон судалгаанаас жишээ авахад:

- дэлхийн нийт улс төрчдийн 13% нь эмэгтэйчүүд,
- хамгийн хүчирхэг компаниудын ТУЗ-н гишүүдийн 15%- нь эмэгтэйчүүд
- ашгийн бус байгууллагуудын хувьд ч шийдвэр гаргагчдын дунд бүсгүйчүүдийн эзлэх хувь 20-оос хэтэрдэггүй юм байна.

Гэтэл анх ажил мэргэжлийн гараагаа эхлэхдээ охид, хөвгүүд бүгд л ижил мэдлэг, боловсрол туршлагатай байдаг.

ЯАГААД ЭМЭГТЭЙ МАНЛАЙЛАГЧИД ЦӨӨХӨН БАЙДАГ ВЭ?

Түүхэн уламжлалаас үүдэн “захирагч” буюу шийдвэр гаргагч нь эрэгтэй хүн, дагагч нь эмэгтэй хүн байдаг гэсэн үзэл бидний далд ухамсарт байсаар байна.

Үүнтэй холбоотойгоор шилдэг манлайлагчдын шинж чанаруудыг ч “дайчин, овсгоотой, зоригтой, итгэлтэй,” байдаг гэж тодорхойлдог ба эмэгтэйчүүдийн байгалиас заясан шинжүүд энэхүү дүр зурагт тохирдоггүй тул тэднийг удирдагчаар сонгох нь мөн цөөн.

БОЛОМЖ БАЙНА УУ?

Монгол Улсын Үндсэн Хууль	• “Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна гэж заасан байдаг • Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заажээ
Иргэний хууль (2002)	• Монгол улсын иргэн бүр иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш, оролцож, эрх үүргээ эдэлнэ гэж заасан байдаг. • Иргэний хуулийн 520-р зүйлд зааснаар хүү, охины аль аль нь хуулийн дагуу гэр бүлийн өмчийг өвлөн авах эрхтэй • нас барагчийн нөхөр эхнэр мөн гэр бүлийн өмчийг өвлөх адил тэгш эрх эдэлнэ • Иргэний хуулийн 520-р зүйл • Гэр бүл болоогүй эмэгтэй, эрэгтэй өмч хөрөнгө эзэмшихдээ тэгш эрх эдэлнэ. Иргэний хуулийн. 101.1 болон 127.2

БОЛОМЖ БАЙНА УУ?

Хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль (1999)	Энэ хуулиар хөдөлмөрийн харилцаанд жендэрт суурилсан алагчлах үзлийг хориглосон байдаг бөгөөд хуулийн зарим бүлэгт жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан зүйл заалт орсон байна. • 7 дугаар бүлгийн 7.4 болон 7.5 - ажилд авах ярилцлагын үеэр ажил олгогч этгээд ажилд орохоор өргөдөл гаргагчийн гэр бүлийн байдлын талаар асуух нь хууль бус үйлдэл болно. • 100 -р зүйлд жирэмсэн эмэгтэйг ажлаас халахыг хуулиар хориглосон байдаг. • 106 - р зүйлд хүүхэд асрах чөлөө нь дууссан эцэг, эхэд ажил олгогч нь түүний ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй. • 103 -р зүйлд Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага олгох үүргийг ажил олгогчид хүлээлгэсэн байдаг. Гэвч жирэмсэн биш, хөхүүл биш эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй нэгэн адил хүнд ажил гүйцэтгэхийг хориглосон байна.
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай	Газар өмчлөлийн харилцаанд Иргэн бүрт газар өмчлүүлэхээр зааснаар эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш эрхтэй оролцох боломж олгосон

БОЛОМЖ БАЙНА УУ?

Гэр бүлийн тухай хууль (1999)	Гэрлэлт цуцлахтай холбоотой заалтад хэрэв эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсвэл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлахыг хориглосон байна. Харин гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн тохиолдолд эхнэр нөхөр хоёр хүүхдийг хэний асрамжинд үлдээх, халамжлах талаар заасан байна
УИХ-ын сонгуулийн тухай	УИХ-ын сонгуулийн тухай хуулийг 2011 онд батлагдсан бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7.2.2 -т:“... улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх” гэсэн заалт байдаг.

БОЛОМЖ БАЙНА УУ?

- Монгол улсад 1924 оноос эхлэн эмэгтэйчүүд сонгуульд оролцох эрхтэй болсон билээ.
- Хэдий тийм боловч улс төрийн шийдвэр гаргах түвшинд, тодруулбал парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай бус хэвээр байна.

	1990	2000	2004	2008	2012	2016
Парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь	24.9	11.8	6.6	3.9	14.47	17,1

БОЛОМЖИЙГ ЯАГААД АШИГЛАХГҮЙ БАЙНА?

Нийгэмд давамгайлдаг үзэл санаанууд:

Эрэгтэй хүн бол оюун санаа болон бие махбодын хувьд эмэгтэйчүүдээс илүү гэсэн ойлголт түгээмэл байна.

Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэй хүн ард түмний аж байдлыг сайжруулахад илүү амжилт гаргах чадавхитай

Цаг агаар болон бусад ямар ч хүнд нөхцөл байдалд, хол явах, машин, мотоцикл жолоодоход эрэгтэй хүн эмэгтэйчүүдээс илүү

Эрэгтэйчүүд өрхийн тэргүүн байдаг учир улс төрд ч мөн лидер, манлайлагч, удирдагч байх ёстой

БИД ХЭРХЭН ӨӨРСДӨДӨӨ БОЛОМЖУУДЫГ ГАРГАЖ БОЛОХ ВЭ?

- *Өөрийгөө чадна гэдэгт итгэлтэй байх.*
- *Ар гэр, хүүхэд өсгөх үүргээ ажилтайгаа хослуулах*
- *Гэрийн ажлуудаа оновчтой хуваарилахад анхаарах*
- *Жирэмсний амралт авах хүртлээ ажлын эрч хүч, зорилгодоо хүрэх тэмүүллээ хадгалсан хэвээр байх*

ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

- *Эмэгтэйчүүд өрсөлдөх чадвараа сайжруулах*
- *Гэр бүлийнхээ асуудлыг шийдэх*
- *Эмэгтэйчүүд санхүүгийн эрх чөлөөтэй*

ЭМЭГТЭЙ МАНЛАЙЛАГЧДЫН ЯЛГАРАХ ШИНЖҮҮД

- *Бусдад нөлөөлөх чадвар*
- *Зорилгоо ухамсарлах чадвар*
- *Мятрашгүй тэвчээр*

ЭМЭГТЭЙ МАНЛАЙЛАГЧДЫН ЯЛГАРАХ ШИНЖҮҮД

- *Жинхэнэ манлайлагч эхэлж сонсож, дараа нь үйлдэл хийдэг.*
- *Жинхэнэ манлайлагч хурцадмал байдалтай үед шийдвэр гаргадаггүй.*
- *Жинхэнэ манлайлагч юуг мэдэхгүйгээ мэддэг.*
- *Жинхэнэ манлайлагч хэзээ ч өрөөнд байгаа хамгийн ухаантай хүн болохыг хүсдэггүй.*
- *Жинхэнэ манлайлагч эцсийн үр дүнгээс илүүтэй үйл явцын ахицыг тэмдэглэдэг.*
- *Жинхэнэ манлайлагч үгүйсгэсэн бус бүтээлч хариу үйлдэл үзүүлдэг.*
- *Жинхэнэ манлайлагч хийх шаардлагатай зүйлээ хэрэгжүүлдэг.*
- *Жинхэнэ манлайлагч эерэг соёлыг бий болгодог.*
- *Жинхэнэ манлайлагч арга замыг үргэлж олдог.*

МАНЛАЙЛАГЧ БАЙХЫН ТУЛД:

- Үргэлж шударга бай.
- Үргэлж хариуцлагатай бай.
- Зүтгэлтэй бай.
- Үргэлж үр дүнтэй харьц
- Үргэлж дагаж буй хүмүүсийг сэргэлдүүлэхээс зайлсхийх
- Үргэлж өөдрөг бай.
- Үргэлж өөрчлөлтөд бэлэн бай
- Үргэлж бусдад хариуцлага оноож бай
- Үргэлж сайн сайхны үлгэр жишээ бай
- Үргэлж сайн сайхны үлгэр жишээ бай

Өөрийгөө бэлтгэх
нь манлайллын
хамгийн гол
түлхүүр мөн.